



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2029 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 341

Улаанбаатар хот

「Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл」 олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2.1, 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн биет бус хөрөнгөд бүртгэлтэй, 10 нэгж талбар, 55304 метр квадрат талбай бүхий, нийт 2,098,502,420.00 (хоёр тэрбум ерэн найман сая таван зуун хоёр мянга дөрвөн зуун хорь) төгрөгийн балансын үнэтэй “газар эзэмших эрх”-ээс хавсралтад заасны дагуу нийт 46 метр квадрат талбай бүхий 1,897,220.00 (нэг сая найман зуун ерэн долоон мянга хоёр зуун хорь) төгрөгийн балансын үнэтэй газар эзэмших эрхийг данснаас хасч, залруулга хийхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө данснаас хасах, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Газар эзэмших эрхийг шинэчлэн баталгаажуулж арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001637

16-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн
.....344..... дугаар тогтоолын хавсралт

"УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН БИЕТ БУС ХӨРӨНГӨД БҮРТЭЛТЭЙ ДАНСНААС
ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Нэгж талбарын дугаар	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Данснаас хасах метр квадрат	Данснаас хасах үнэ (төгрөг)
1	Газар эзэмших эрх (Насос станцын зориулалттай, Э-2206003912 дугаартай)	1780610383	м.кв	399	38,200,260.00	1	95,740.00
2	Газар эзэмших эрх (Насос станцын зориулалттай, Э-2202004016 дугаартай)	1500600858	м.кв	1925	184,299,500.00	2	191,480.00
3	Газар эзэмших эрх (Насос станцын зориулалттай, Э-2206002938 дугаартай)	1780800656	м.кв	1750	167,545,000.00	2	191,480.00
4	Газар эзэмших эрх (Насос станцын зориулалттай, Э-2203008220 дугаартай)	1460200586	м.кв	2109	201,915,660.00	2	191,480.00
5	Газар эзэмших эрх (Насос станцын зориулалттай, Э-2206002964 дугаартай)	1781207628	м.кв	750	22,845,000.00	1	30,460.00
6	Газар эзэмших эрх (Насос станцын зориулалттай, Э-2205001933 дугаартай)	1680910074	м.кв	817	53,333,760.00	1	65,280.00
7	Газар эзэмших эрх (Насос станцын зориулалттай, Э-2204008915 дугаартай)	1330800017	м.кв	1472	96,092,160.00	1	65,280.00

Д/д	Хөрөнгийн нэр	Нэгж талбарын дугаар	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Данснаас хасах метр квадрат	Данснаас хасах үнэ (төгрөг)
8	Газар эзэмших эрх (Насос станцын зориулалттай, Э-2205001989 дугаартай)	1681100063	м.кв	10110	327,361,800.00	9	291,420.00
9	Газар эзэмших эрх (Насос станцын зориулалттай, Э-2206002934 дугаартай)	1781300260	м.кв	35000	913,850,000.00	26	678,860.00
10	Газар эзэмших эрх (Насос станцын зориулалттай, Э-2206003570 дугаартай)	1780800633	м.кв	972	93,059,280.00	1	95,740.00
Нийт дүн				55304	2,098,502,420.00	46	1,897,220.00
					(хоёр тэрбум ерэн найман сая таван зуун хоёр мянга дөрвөн зуун хорь)		(нэг сая найман зуун ерэн долгон мянга хоёр зуун хорь)